



Аргаль хонины мониторингийн судалгаа

Аргаль хонь нь Монгол орны ховор амьтны нэг тул 1953 оноос агнахыг хуулиар хориглож дархан цаазтай болгосны дээр Зэрлэг амьтан ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах Конвенц(CITES)-ийн II хавсралтад оруулсан.



Аргаль хонины тархацын 23.4% бүхий байршил нутгийг улсын тусгай хамгаалалтад (7 дархан газар, 7 байгалийн цогцолбор газар, 6 байгалийн нөөц газар) хамруулсан.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газраас санаачлан 2000 оны 10 дугаар сард **“Монгол орны аргаль хонины стратегийн төлөвлөлт”** Үндэсний семинарыг зохион байгуулж, зөвлөмж боловсруулсан. Уг семинараас гарсан зөвлөмжийн дагуу Байгаль орчны яам 2001 онд нэгдсэн нэг арга зүй ашиглан аргаль хонины тархац, нөөцийг тогтоох ажлыг зохион байгуулсан. Энэ судалгаагаар Монгол улсын 15 аймгийн 110 сумын 47815 км² талбай бүхий үндсэн байршил нутагт 13-15 мянга орчим аргаль хонь байна гэж тогтоожээ. Аргаль хонины нөөц нь 1975-1985 оны үеэс 72.0% -76.6%-иар буурсан байна. Баян-Өлгий, Ховд, Говь –Алтай, Баянхонгор, Завхан, Увс, Архангай зэрэг 7 аймагт аргаль хонины тархац багасаж 34 сум буюу дээрх аймгуудын аргаль хонь бүхий нийт сумдын 31,2% нь огт аргальгүй болжээ (С.Амгаланбаатар., 2002). Аргаль хонины нөөц эрс буурсан тулд амьдрах орчинг хамгаалах, түүнд учирж буй аюулыг бууруулах шаардлага тулгарч 2002 онд “Аргаль хонийг хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулсан (Засгийн газрын 269 дүгээр тогтоол, 2002).

Аргаль хонь нь Оросын холбооны улс, Монгол улсын хилийн орчимд Алтай таван богд уулын ар, Сийлхэмийн нуруу, Чихачевийн нуруу, Мөнгөн Тайга, Хархираа, Сийлхэмийн салбар уулс Цагаан гол, Гүн сайр, Хөх сайрд нийтдээ 10950 км² талбайд 1060-1140 орчим аргаль хонь тархжээ. Энэ нь Федосенкогийн тооцоолсноор (2000) Алтайн аргалийн популяцийн 24% бөгөөд бүс нутгийн төдийгүй Төв Азийн аргаль хонийг хамгаалахад ач холбогдол бүхий популяци юм (Палцин, 2004).

Аргаль хонины нэгдсэн тооллогоор Увс аймагт 811 км² нутагт 550-600 орчим аргаль хонь байршдаг гэж үнэлжээ (С.Амгаланбаатар, 2001). Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санаачлагаар Увс аймгийн засаг даргын захиалгаар 2004 онд зохион байгуулсан агнуур зохион байгууллалтын дүн дээрх дүнтэй адил гарсан. Оросын холбооны улс, Монголын судлаачид нэг хугацаанд ижил арга зүйгээр 2003 онд судалгаа хийсэн. Судалгаагаар Увс аймгийн улсын хил орчимд Монголын талд Бөхмөрөн, Сагил сумд нийт 453 км² нутагт 220-240 орчим аргаль хонь байршдаг болохыг тогтоосон. Улсын хил орчмын аргаль хонины шилжилт хөдөлгөөнд шинээр байгуулсан хилийн тор сөргөөр нөлөөлж байна гэж үздэг (Ё.Онон, 2003). Энэ нь улсын хил орчмын аргаль хонины популяцийн 23.5% -ийг эзэлж байгаа бөгөөд жил бүр 5-7 угалзыг тусгай

зөвшөөрлөөр гадаадын иргэдэд агнуулдаг. Тиймээс энэ популяцийн амьдрах орчинг хадгалах, зохистой ашиглах, хамгаалах менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай юм. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар нь Увс аймагт улсын хилийн орчмын аргаль хонины нүүдэл, шилжилт, тоо толгой түүнд нөлөөлж буй гэрийн малын нөлөөлөлийг тодорхойлох мониторингийн судалгааг 2005 оны 04 дүгээр сараас эхлэн явуулж байна. Судалгааны үр дүн нь энэ зүйл амьтныг хамгаалах, зохистой ашиглах агнуурын менежментийг бий болгоход суурь мэдээлэл болох юм.



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь Хөтөлбөрийн газраас боловсруулав.

Дэлгэрэнгүй мэдээллийг onon@wwf.mn хаягаар авч болно.